



АУДИТЫН КОД: САГ-2017/21/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан

Утас: 261628 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	АУДИТЫН ТАЙЛАН.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.5	Дотоод хяналт	6
2.6	Төсвийн ОРЛОГО ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ талаарх тайлбар, тодруулга....	6
2.7	Шилэн дансны мэдээлэл	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Аудитаар илэрсэн зөрчлийн талаар.....	7
2.9.2	Төсвийн хэтрэлтийн талаар.....	7
2.9.3	Авлага, өр төлбөр дансдын үлдэгдлийн талаар.....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.1	аудитаар илэрсэн зөрчил	11
3.2	төсвийн хэтрэлт.....	12
3.3	авлага, өр төлбөр.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
У.ХҮРЭЛСҮХ ТАНАА

2017.04.25 № 754
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Шадар сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2017\0425SAG28.Docx

070183

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны

4 дүгээр сарын 05-наас 2017 оны 04 дүгээр сарын 21-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хэрэгжүүлэв.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ЗГ-2/110 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Шадар сайд нь үйл ажиллагааны чиглэлээр гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах, стандартчилал, хэмжил зүйн асуудал, шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг ил тод болгох, цахимжуулах, оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн болон тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудлыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг, зорилготой ажиллаж ирсэн байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлэв.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 2 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 3 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу

мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон ахлах аудитор гүйцэтгэлээ.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж буй ажилтнуудын үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

2.6 Төсвийн ОРЛОГО ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг Монгол Улсын Шадар сайд хянаж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжигдсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт 119,990.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, 113,693.4 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 6,297.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансыг төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулсан талаар удирдлагын шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй ойлгомжтой хөтөлсөн байна.

Тухайлбал Мэргэжлийн хяналтын ерөнхий газар <https://www.shilendans.gov.mn/org/429> цахим холбоосоор, Онцгой байдлын ерөнхий газар <https://www.shilendans.gov.mn/org/428> цахим холбоосоор, Стандартчилал хэмжил зүйн газар <https://www.shilendans.gov.mn/org/426> цахим холбоосоор төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг толилуулсан байна.

Аудитын дүнгээр Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх төлөвлөгөөгөөр

төлөвлөлтийн шатанд 2 /авлага, өр төлбөр/ дансанд эрсдэл байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар тулган баталгаажуулах, ажиглах, харьцуулах зэрэг сорилыг гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 7 ажилбараар тус тус гүйцэтгэв.

Мөн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, нотлох баримтуудыг тусгайлан ажлын баримтад хавсаргав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитын дүнгээр нийт 20,691.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,346.5 сая төгрөгийн материаллаг алдааг санхүүгийн тайланд залруулж, 6.4 сая төгрөгийн 9 төлбөрийн акт, 197.1 сая төгрөгийн 18 албан шаардлага тогтоож, 17,141.5 сая төгрөгийн 134 зөвлөмж өгөгдсөн байна.

Шийдвэрлэсэн: Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тавьсан акт, өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж биелэлтийг УАГ-т албан бичгээр мэдэгдэх талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх.

2.9.2 Төсвийн хэтрэлтийн талаар

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 119,990.9 сая төгрөг батлагдсанаас 113,693.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлын бүлгийн дүнгээр хэтрүүлээгүй боловч тэтгэврийн даатгалын зардал 106.6 сая, гэрэл цахилгааны зардал 108.7 сая, бичиг хэргийн зардал 13.3 сая, ном хэвлэлийн зардал 4.0 сая, эм бэлдмэл авах зардал 1.0 сая, хоол хүнсний зардал 45.2 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал 15.5 сая, нийт 6 нэрийн зардал 294.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид төсвийн зардлыг нэр төрлөөр хэтрүүлэхгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтыг баримталж ажиллах, мөн дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах.

2.9.3 Авлага, өр төлбөр дансдын үлдэгдлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 6,655.3 сая төгрөгийн өр төлбөр, 4,067.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт хэрэгжээгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид тайлант хугацаанд үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулж байх, авлага, өр төлбөрийг барагдуулах ажлын хэсэг гаргаж ажиллах, олон жилийн насжилтай эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өр төлбөрийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг нэмэгдүүлсэн, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй төсвийн захирагч нартай хариуцлага тооцдог байх талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Аудитын явцад:

- Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж буй Сангийн яамны “Э-тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй,
- Төрийн сангийн газраас ирүүлсэн ТЕЗ болон Сангийн яам хоорондын тооцоо нийлсэн баримтад хөрөнгийн санхүүжилт, зардлын гүйлгээг тусгаагүй,
- Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн “Э-тайлан” програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдсан байна.

Эдгээр нь ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсгэх магадлалтай байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛИЙН НЭГТГЭЛ

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад аудитын дүнгээр нийт 20,897.7 төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6.4сая төгрөгийн 9 төлбөрийн акт тавигдаж, 197.1 сая төгрөгийн 18 албан шаардлага, 17,347.7 сая төгрөгийн 134 зөвлөмж тус тус өгсөн ба санхүүгийн тайланд 3,346.5 сая төгрөгийн залруулга хийж ажиллав.

Нийт илэрсэн алдаанаас 203.5 сая төгрөгийн акт, албан шаардлагын дүнг материаллаг алдаанд тооцож үлдсэн 17,347.7 сая төгрөгийн алдааг материаллаг бус алдаагаар тооцов.

Илэрсэн 203.5 сая төгрөгийн материаллаг алдаа нь бидний үнэ цэнээр тооцсон материаллаг түвшин 2,273.8 сая төгрөгөөс бага байгаа учраас Зөрчилгүй санал дүгнэлтийн төсөл боловсруулав.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 4 зөвлөмжийг тус бүр 50 хувьтай биелүүлж, Үндэсний аудитын газарт 2017 оны 02 сарын 14-ний өдрийн х/121 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна. /Загвар 9, албан бичиг/

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Аудитын төлөвлөлтийн шат болон гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг 2016 оны жилийн эцсийн тайланд толилуулсан 113,693.4 сая төгрөгийн нийт зардлын 2 хувиар тооцож 2,273.8 сая төгрөгөөр тогтоов.

Төлөвлөлтийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг алдаа илэрсэнгүй.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бид Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад аудитын дүнгээр нийт 20,897.7 төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6.4сая төгрөгийн 9 төлбөрийн акт тавигдаж, 197.1 сая төгрөгийн 18 албан шаардлага, 17,347.7 сая төгрөгийн 134 зөвлөмж тус тус өгсөн ба санхүүгийн тайланд 3,346.5 сая төгрөгийн залруулга хийж ажиллав.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

-Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тавьсан акт, өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж биелэлтийг ҮАГ-т албан бичгээр мэдэгдэх талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх.

-Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 ТӨСВИЙН ХЭТРЭЛТ

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 119,990.9 сая төгрөг батлагдсанаас 113,693.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлын бүлгийн дүнгээр хэтрүүлээгүй боловч тэтгэврийн даатгалын зардал 106.6 сая, гэрэл цахилгааны зардал 108.7 сая, бичиг хэргийн зардал 13.3 сая, ном хэвлэлийн зардал 4.0 сая, эм бэлдмэл авах зардал 1.0 сая, хоол хүнсний зардал 45.2 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал 15.5 сая, нийт 6 нэрийн зардал 294.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

-Цаашид төсвийн зардлыг нэр төрлөөр хэтрүүлэхгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах, мөн дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах.
-Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.3 АВЛАГА, ӨР ТӨЛБӨР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 6,655.3 сая төгрөгийн өр төлбөр, 4,067.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт хэрэгжээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид тайлант хугацаанд үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулж байх, авлага, өр төлбөрийг барагдуулах ажлын хэсэг гаргаж ажиллах, олон жилийн насжилтай эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, өр төлбөрийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг нэмэгдүүлсэн, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй төсвийн захирагч нартай хариуцлага тооцдог байх.

-Энэхүү зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хууль, тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/	
	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,153,498.7	99,241,735.6
МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,864.5	273,215.0
АВЛАГА	4,353,501.8	4,067,785.8
УРЬДЧИЛГАА	1,456,446.7	193,410.2
БАРАА МАТЕРИАЛ	28,643,957.6	29,649,636.8
НӨӨЦИЙН БАРАА	63,562,728.1	65,057,687.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	140,118,404.4	181,573,746.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	140,118,404.4	181,573,746.1
Биет хөрөнгө	139,925,152.8	181,217,402.9
Биет бус хөрөнгө	193,251.5	356,343.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	238,271,903.0	280,815,481.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,883,783.2	6,655,313.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,883,783.2	6,655,313.8
Богино хугацаат үнэт цаас	625,468.3	0.0
Өглөг	5,249,114.5	6,077,799.7
Урьдчилж орсон орлого	9,200.4	577,514.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	232,388,119.8	274,160,168.0
Засгийн газрын хувь оролцоо	232,388,119.8	274,160,168.0
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	96,599,337.8	99,112,220.0
Хуримтлагдсан үр дүн	116,958,927.3	156,197,734.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,829,854.8	18,850,213.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	238,271,903.0	280,815,481.7

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/	
	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	194,370,660.9	161,951,621.4
ТАТВАРЫН ОРЛОГО	4,654,507.3	0.0
Орлогын албан татвар	4,654,507.3	0.0
Хувь хүний орлогын албан татвар	4,654,507.3	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,287,719.6	32,113,515.0
Нийтлэг татварын бус орлого	60,982,987.4	26,910,930.1
Тусламжийн орлого	2,304,732.3	5,202,584.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	126,428,434.0	129,838,106.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	151,562,633.0	143,106,290.2
УРСГАЛ ЗАРДАЛ	136,390,952.4	126,788,226.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,926,129.4	105,573,908.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,589,615.9	64,386,604.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,837,530.8	3,820,356.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,356,658.8	4,559,082.3
Хангамж, бараа материалын зардал	3,678,727.7	4,289,918.3
Нормативт зардал	3,202,723.4	4,201,568.4
Эд хогшил, урсгал засварын зардал	6,104,221.6	2,240,509.6
Томилолт, зочны зардал	1,779,970.9	1,401,972.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,055,352.4	1,748,789.0
Бараа үйлчилгээний бусад зардал	21,321,328.0	18,925,107.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,464,823.0	21,214,317.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,171,680.6	16,318,064.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	42,808,027.9	18,845,331.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	17,054.8	26,243.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,741,927.8	1,279,533.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)- (V)	23,083,154.9	17,592,040.2

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ /ӨМЧ
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,340,862.4	0.0	209,340,862.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	135,031.7	0.0	135,031.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,475,894.1	0.0	209,475,894.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-233,267.5	0.0	-233,267.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	62,338.3	0.0	62,338.3
Тайлант үеийн үр дүн	23,083,154.9	0.0	23,083,154.9
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,388,119.8	0.0	232,388,119.8
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,388,119.8	0.0	232,388,119.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,182,171.6	0.0	24,182,171.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	256,570,291.5	0.0	256,570,291.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,163.7	0.0	-2,163.7
Тайлант үеийн үр дүн	17,592,040.2	0.0	17,592,040.2
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,160,168.0	0.0	274,160,168.0

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/	
	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	137,369,737.0	151,076,190.0
ТАТВАРЫН ОРЛОГО	3,827,258.1	0.0
Орлогын албан татвар	3,827,258.1	0.0
Хувь хүний орлогын албан татвар	3,827,258.1	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,697,574.8	20,332,921.2
Нийтлэг татварын бус орлого	6,590,058.8	19,869,433.6
Тусламжийн орлого	1,036,542.7	463,487.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	70,973.3	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125,844,904.1	130,743,268.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	113,820,206.7	118,563,743.4
УРСГАЛ ЗАРДАЛ	113,820,206.7	118,563,743.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,902,950.5	100,252,715.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	63,182,279.6	64,383,426.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,814,096.8	3,813,054.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,826,078.2	4,721,920.7
Хангамж, бараа материалын зардал	3,280,097.5	3,289,657.4
Нормативт зардал	4,015,766.5	3,932,834.2
Эд хогшил, урсгал засварын зардал	796,660.4	1,736,927.7
Томилолт, зочны зардал	1,951,357.9	1,463,835.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,919,880.8	3,142,511.3
Бараа үйлчилгээний бусад зардал	5,116,732.9	13,768,548.6
ТАТААС	0.0	978.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,917,256.3	18,310,049.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,549,530.3	32,512,446.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,514,226.0	32,376,096.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,514,226.0	32,376,096.1
Дотоод эх үүсвэрээр	23,514,226.0	32,376,096.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-23,514,226.0	-32,376,096.1
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,304.4	136,350.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	101,560.2	136,864.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	136,864.5	273,215.0

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

код	ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	ЗӨРҮҮ	ХУВЬ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,990,900.3	113,693,399.3	6,297,501.0	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,911,966.1	91,602,096.3	2,309,869.8	97.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,857,911.3	85,513,555.1	2,344,356.2	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,416,103.0	64,282,183.7	1,133,919.3	98.3
210101	Үндсэн цалин	60,903,334.0	59,906,614.1	996,719.9	98.4
210102	Нэмэгдэл	38,901.6	38,901.6	0.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,857,858.2	1,781,721.5	76,136.7	95.9
210105	Гэрээт ажлын хөлс	3,826,181.7	3,796,751.7	29,430.0	98.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,905,673.2	2,012,289.1	-106,615.9	99.2
210201	Тэтгэврийн даатгал	226,313.5	214,830.9	11,482.6	105.6
210202	Тэтгэмжийн даатгал	291,519.6	248,593.5	42,926.1	94.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	63,540.8	59,162.7	4,378.1	85.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,339,134.6	1,261,875.5	77,259.1	93.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,822,052.6	4,685,982.1	136,070.5	94.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	943,238.1	1,051,966.8	-108,728.7	97.2
210301	Гэрэл, цахилгаан	2,700,300.8	2,550,627.5	149,673.3	111.5
210302	Түлш, халаалт	313,481.1	249,549.8	63,931.3	94.5
210303	Цэвэр, бохир ус	865,032.6	833,838.0	31,194.6	79.6
210304	Байрны түрээс	2,784,480.1	2,637,887.6	146,592.5	96.4
2104	Хангамж, бараа материалын зардал	250,996.8	263,002.5	-12,005.7	94.7
210401	Бичиг хэрэг	1,928,867.6	1,770,410.2	158,457.4	104.8
210402	Тээвэр, шатахуун	425,116.1	425,856.9	-740.8	91.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	936.0	4,946.3	-4,010.3	100.2
210404	Ном, хэвлэл	17,903.2	14,924.0	2,979.2	528.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,660.4	158,747.7	1,912.7	83.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,875,235.7	3,850,364.1	24,871.6	98.8
2105	Нормативт зардал	460,732.4	461,815.0	-1,082.6	99.4

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	576,371.6	621,628.0	-45,256.4	100.2
210502	Хоол, хүнс	2,838,131.7	2,766,921.1	71,210.6	107.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,290,644.8	1,241,542.3	49,102.5	97.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	617,266.6	601,310.8	15,955.8	96.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,615.2	47,125.0	-15,509.8	97.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,262.4	344,372.8	5,889.6	149.1
210604	Урсгал засвар	0.0	16,062.9	-16,062.9	92.4
2107	Томилолт, зочны зардал	350,102.4	328,309.9	21,792.5	98.3
210701	Гадаад албан томилолт	2,896,372.2	2,591,065.1	305,307.1	0.0
210702	Дотоод албан томилолт	1,692,355.5	1,416,564.4	275,791.1	93.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	743,264.8	738,122.4	5,142.4	89.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,881.3	44,574.1	5,307.2	83.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,252.9	14,060.5	1,192.4	79.4
210803	Даатгалын үйлчилгээ	97,704.1	96,140.6	1,563.5	99.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,407.7	87,330.2	2,077.5	89.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	188.4	5.5	182.9	92.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	151,292.0	149,000.4	2,291.6	98.4
210807	Газрын төлбөр	2,596,578.8	2,083,405.6	513,173.2	97.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,328,903.3	1,827,639.9	501,263.4	2.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	267,675.5	255,765.8	11,909.7	98.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,054,054.8	6,088,541.2	-34,486.4	80.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	192,525.8	318,488.2	-125,962.4	78.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	127,230.2	-127,230.2	95.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,398,378.5	102,846,922.1	2,551,456.4	100.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	105,398,378.5	102,846,922.1	2,551,456.4	165.4
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,961,256.5	10,404,929.8	3,556,326.7	0.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,750,651.9	1,654,639.8	3,096,012.1	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	100,210.0	-100,210.0	98.4

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	631,265.3	463,487.6	167,777.7	78.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.0	54,059.2	-54,059.2	50.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,358,394,400.0	5,376,302,785.3	17,908,385.3	100.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,078,934,200.0	22,091,302,990.0	3,987,631,210.0	84.7
220001	Барилга байгууламж	8,899,112,000.0	8,409,868,968.0	489,243,032.0	94.5
222001	Тоног төхөөрөмж	9,100,080,000.0	8,966,215,766.0	133,864,234.0	98.5
224001	Стратегийн нөөц хөрөнгө	8,079,742,200.0	4,715,218,256.0	3,364,523,944.0	58.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,990,900,300.00	113,715,339,519.43	6,275,560,780.57	94.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,398,378,500.0	102,846,922,089.6	2,551,456,410.4	97.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	105,398,378,500.0	102,846,922,089.6	2,551,456,410.4	97.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,961,256,500.0	10,404,929,829.8	3,556,326,670.2	74.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,750,651,900.0	1,654,639,825.2	3,096,012,074.8	34.8
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	100,210,004.6	-100,210,004.6	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,210,604,600.0	8,650,080,000.0	560,524,600.0	93.9
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	631,265,300.0	463,487,600.0	167,777,700.0	73.4
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	631,265,300.0	463,487,600.0	167,777,700.0	73.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	54,059,160.1	-54,059,160.1	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	76,650,932.4	-76,650,932.4	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13,516.0	13,270.0	246.0	98.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	122.0	122.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	122.0	122.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6,697.0	6,574.0	123.0	98.2
620001	Удирдах ажилтан	153.0	153.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5,530.0	5,397.0	133.0	97.6
620003	Үйлчлэх ажилтан	593.0	602.0	-9.0	101.5
620004	Гэрээт ажилтан	421.0	422.0	-1.0	100.2

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6,697.0	6,574.0	123.0	98.2
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,922.0	1,894.0	28.0	98.5
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3,620.0	3,520.0	100.0	97.2
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	734.0	742.0	-8.0	101.1
650010	Гэрээт ажилтан	421.0	418.0	3.0	99.3